

БАТЛАВ:

ХОВД АЙМГИЙН БОГ-ЫН ДАРГА: _____ /Ч.НЭРГҮЙ/

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ВЕСТЕРН ХОЛД” ХХК-ийн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: _____ /Б.ЭНХБАТ/



“ВЕСТЕРН ХОЛД” ХХК ХОВД АЙМГИЙН БУЯНТ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ

“ХОВД ЭКО ЦЕМЕНТ” ҮЙЛДВЭРИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Вестерн Холд” ХХК Улсын бүртгэлийн дугаар:
1611002075, Регистрийн дугаар: 4065115**

Хянасан:

Ховд аймгийн БОГ-ын
мэргэжилтэн: _____ /Б. Ариундолгор/

Боловсруулсан:

“ВЕСТЕРН ХХК-ийн

Байгаль орчны менежер: _____ /Б.Дэлгэрмаа/

ХОВД АЙМАГ

2026 ОН

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.ҮЙЛДВЭРИЙН ТАНИЛЦУУЛГА

- 1.1. Үйлдвэрийн ерөнхий мэдээлэл
- 1.2. Үйлдвэрийн тодорхойлолт, хүчин чадал
 - 1.2.1. Үйлдвэрийн тодорхойлолт
 - 1.2.2. Үйлдвэрийн хүчин чадал

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮЙЛДВЭРИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

- 2.1. Үйлдвэрийн байршил
- 2.2. Газрын гадарга
- 2.3. Усан сүлжээ
- 2.4. Үйлдвэрийн талбай орчмын уур амьсгалын горим
- 2.5. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал
- 2.6. Ургамлын нөмрөгийн төлөв байдал
- 2.7. Амьтны аймаг
- 2.8. Түүх соёлын биет өв, дурсгалууд
- 2.9. Хүн ам, эдийн засаг, зам харилцаа

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛТИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 3.1. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл
- 3.2. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл
- 3.3. Нийгэм-эдийн засагт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- 4.1. Төлөвлөгөөний зорилго
- 4.2. Гол зорилтууд

ТАВДУГААР БҮЛЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

- 5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
- 5.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө
- 5.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
- 5.4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
- 5.5. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

5.6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

5.7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

5.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

5.9. “Вестерн Холд” ХХК-ийн “Ховд эко цемент” үйлдвэрийн 2026 оны БОМТ-ний нийт зардал


1. ҮЙЛДВЭРИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Үйлдвэрийн ерөнхий мэдээлэл

Үйлдвэрийн нэр:	“Ховд Эко Цемент” Цементийн үйлдвэр
Хэрэгжүүлэгч:	“Вестерн Холд” ХХК Улсын бүртгэлийн дугаар:1611002075 Регистрийн дугаар: 4065115
Үйлдвэрийн хаяг:	Монгол улс, Ховд аймаг, Жаргалант сум, Баатархайрхан баг, Вестерн Холд ХХК-ний Байр. Утас: 976-99432002, 11-25180
Үйлдвэрийн зорилго ач холбогдол:	Цементийн үйлдвэрийн үндсэн түүхий эд болох шохойн чулууны “Шохойт”ордод түшиглэн, баруун бүсийн 5 аймгийн цементийн хэрэгцээг бүрэн хангах, орчин үеийн дэвшилтэт технологи бүхий хуурай аргын үйлдвэр нь тус бүс нутагт орших албан газар, ААН, байгууллага, амьдарч буй ард иргэдийг олон улсын стандартад бүрэн нийцсэн, чанартай бүтээгдэхүүнээр үнийн хямд, тогтвортой нөхцөлөөр хангаж, ая тухтай амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.
Үйлдвэрийн байршил:	Ховд аймгийн Буянт сумын Норжинхайрхан багийн нутагт орших Шохойт болон Цахирын ордын дэргэд аймгийн төвөөс 15 километр, Буянт сумаас 16 километрт байрлана. Аймгийн төвөөс хатуу хучилттай авто замаар явж хүрэх ба “Шохойт” нэртэй өөрийн эзэмшлийн үндсэн орд болох шохойн чулуун ордын хажууд 2.5 км зайд байрлана. ➤ Талбайн хэмжээ: 20.0 га; ➤ Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: М-46-136.

Хүснэгт 1. Үйлдвэрийн талбайн солбицол

Эргэлтийн /булангийн цэгийн дугаар/		X	Y
Үйлдвэрийн талбай	1	5328574.377	406412.294
	2	5328832.828	406573.825
	3	5328470.911	407132.564
	4	5328216.919	406971.217



Зураг 1. Үйлдвэрийн талбайн байршил

1.2. Үйлдвэрийн тодорхойлолт, хүчин чадал

1.2.1. Үйлдвэрийн тодорхойлолт

Тус үйлдвэр нь гаднын хараат байдлыг бүрэн таслан зогсоож, дотооддоо нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд оршино. Ховд Эко цементийн үйлдвэр нь баруун бүсийн аймгуудын цементийн хэрэгцээг бүрэн хангаад зогсохгүй Монгол Улсын цементийн одоогийн нийт импортыг бууруулах боломжийг нээж өгч байна. Хамгийн чухал нь томоохон барилга байгууламжид шаардагдах өндөр чанартай, стандартын шаардлага хангасан цементийг эх орондоо хуурай аргаар буюу хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий ус, цахилгаан хамгийн бага зарцуулдаг технологиор үйлдвэрлэх юм.

Ховд аймаг нь Баруун бүсийн хөгжлийн тулгуур төв болон хурдацтай хөгжиж байгаа ба хойд талаараа Увс аймагтай, баруун талаараа Баян-Өлгий аймагтай, зүүн талаараа Завхан аймагтай, урд талаараа Говь-Алтай аймагтай тус тус хил залгаа байрладаг. Баруун аймгуудын дэд бүтцийн салбар ялангуяа барилгын салбарын хурдацтай хөгжлийг дагаад түүхий эд, материалын хэрэглээ өсөж байна.

1.2.2. Үйлдвэрийн хүчин чадал

Үйлдвэр нь өдөрт 1000 тонн клинкер, жилдээ 250,000 тонн стандартын шаардлага хангасан цемент үйлдвэрлэнэ. Үйлдвэр нь 24 цагийн тасралтгүй ажиллагаатай ажиллана. Үүнд үйлдвэрийн бүтээмж гаргаж ажиллах цаг 21 цаг, тосолгоо үйлчилгээ 1 цаг, амралт хоолны цаг 1 цаг, ээлж хүлээлцэх цаг 1 цаг нийт 24 цаг байна.

Цементийн үйлдвэр нь үндсэн түүхий эд болох Ховд аймгийн Шохойтын ордыг түшиглэн, мөн баруун бүсийн 5 аймгийн цементийн хэрэгцээг бүрэн хангахуйц орчин үеийн дэвшилтэт технологи бүхий цементийг үйлдвэрлэж, баруун бүсийн алс хязгаар нутагт амьдарч буй ард иргэдийг олон улсын стандартад бүрэн нийцсэн, чанартай бүтээгдэхүүн, хямд үнэ, тогтвортой нөхцөлөөр хангана.

Бүтээгдэхүүний чанар нь Монгол улсын **MNS 0974 : 2008 стандарт**, Олон улсын **ISO 9001, 14001, 18001 стандартыг** хангана.

Хүснэгт 2. Ажиллах хүч

Удирдлага, инженер техникийн ажилтан	40
Үйлдвэрийн ажилчид	175
Ээлжийн тоо	3
Нийт ажиллагсад	300-350


Цементийн үйлдвэр нь дараах бүтэцтэй байна:

Үүнд:

- Түүхий эд материалыг агуулж хадгалах бункерүүд;
- Түүхий эд материалыг бутлах, тээрэмдэх;
- Түүхий эдийг дамжуулах, жигдрүүлэх, тохируулах;
- Түүхий эдийн хольцын агуулах, силос;
- Эргэх зуух;
- Нүүрсний агуулах;
- Клинкерийн хөргүүр;
- Ус цэвэршүүлэгч байгууламж;
- Клинкерийн силос, нөөц жигдрүүлэгч;
- Цементийн тээрэм;
- Эцсийн бүтээгдэхүүний агуулах, жигдрүүлэх силос;
- Цахилгаан фильтр;
- Бүтээгдэхүүний савлагааны машин;
- Үйлдвэрийн удирдлагын байр;
- Лабораторийн байр;
- Ажилчдын амралтын байр;
- Ресторан, зоогийн газар, зочдын байр;
- Дэд станцын барилга;
- Авто зам талбай;
- Засвар механик цехийн байр;
- Төв оффисын байр.

2. ҮЙЛДВЭРИЙН ТАЛБАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Үйлдвэрийн байршил: Үйлдвэрийн талбай нь Улаанбаатар хотоос 1,465.0 км, Ховд аймгийн төвөөс 15.0 км зайд Буянт сумын нутагт байрлана. Аймгийн төвөөс хатуу хучилттай авто замаар явж хүрэх ба “Шохойт” нэртэй өөрийн эзэмшлийн үндсэн орд болох шохойн чулууны ордын хажууд 2.5 км зайд байрлана.



Зураг 2. Талбайн байршлын агаар, сансрын зураг

2.2. Газрын гадарга: Буянт сум Ховд аймгийн зүүн хойд хэсэгт байрлах ба байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлалаар бүхэлдээ Монгол Алтайн өндөр уулын мужийн Хархираа-Түргэний өндөр уулс, хотгорын тойрог, Алтайн ар говийн цөлөрхөг мужийн Хяргас нуурын хотгорын тойрогт багтаж байна. Уг нутагт өндөр уулын бүсийн уулс, цав толгод, ухаа гүвээт тал, уулс хоорондын хотгор хамарна.

Буянт сум нь Алтайн уулархаг муж, Их нууруудын сав газарт 367,950.0 га нутаг эзлэн оршдог. Газар хөдлөлийн эрчим 8 балл. Сумын нутаг дэвсгэрээр улсын чанартай засмал зам дайрч өнгөрдөг ба баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон зэрэг дэд бүтцийн давуу талуудтай. Улаанбаатар хотоос 1,512.0 км, Аймгийн төвөөс 25.0 км зайд байрладаг. Зүүн талаараа Ховд аймгийн Мянгад сум, урд талаараа Чандмань, Манхан сум, баруун талаараа Дуут сум, хойд талаараа Ховд сумтай хиллэдэг. Буянт сум нь засаг захиргаа нутаг дэвсгэрийн хувьд Норжинхайрхан, Нарийн гол, Цагаан бургас, Наранхайрхан, Цагаан эрэг гэх 5 багтай.

Цементийн үйлдвэр нь II зэргийн хөрсний бүтцэд хамаарах тул газар хөдлөлтийн эрчмийг 8 баллаар тооцож авсан байвал зохино. Сумын нутаг дэвсгэр ерөнхийдөө идэвхтэй бүсэд оршдог ба 8 баллын газар чичирхийллийн мужид хамаарагдаж, газар

хөдлөлтийн голомт үүсэж болох бүс нь 6.2-6.9 магнитуд (рихтерийн шатлалаар) зэрэгт хамаарагдана.

Судалгааны талбайд дундаж өндөр уулс (2,000.0-2,500.0 м), нам уулс (1,500.0-2,000.0 м), уулс хоорондын хөндий, налуу тал, голын хөндий гэсэн хотгор гүдгэрийн үндсэн хэв шинжүүд тархжээ. Үүнд:

- Судалгааны районд хамрагдах уулсаас дундаж өндөр уулст Хойд Ямаат Улаан уул (2,047.7 м), Урд Ямаат Улаан уул (2,026.4 м) тус тус орно. Эдгээр уулс нь шовх оройтой, эгц хажуутай, бэл нь богино бөгөөд шууд голын хөндийтэйгөө залгана;
- Нам уул нь: Улаан богоч (1,710.6 м), Бичигтийн хөтөл (1,647.2 м), Хар толгой уул (1624 м), Баатархайрхан уул (1,606.0 м), Бугат уул (1,727.4 м) тус тус орно. Эдгээр уулс нь шовхдуу оройтой, налуу хажуутай бэл нь богино бөгөөд шууд уул хоорондын хөндийд, налуу тал зарим хэсгээрээ голын хөндийтэйгөө залгана;
- Ховд хотын төв, Урд Улаан уул, Бичигтийн хөтөл, Баатархайрхан уулын Судалгааны районд хамрагдах нутгаас уул хоорондын хөндий болон налуу талархаг хооронд орших хэсэг орно. Энд гадарга нь голын хөндийрүүтээ аажим налуу, талархаг байна.

Голын хөндий нь эхэн хэсэгтээ V маягийн хэлбэртэй байдаг бол адаг руугаа U маягийн хөндийд орох ба голын татам хөндийн сайн хэлбэржсэн хэсгээрээ ширэгтэй боловч хайргархаг гадарга зонхилно. Буянт голын хөндий нь урсгалын дунд хэсгээрээ хөндий нь ихэнхдээ сайн хэлбэржиж дэнж үүсгэсэн байдаг. Судалгааны районы гадаргын налуу нь Буянт голын хөндий орчимд 3°, нам болон дундаж өндөр уулстаа 6°-12° налуутай, налуу тал ба уул хоорондын хөндийдөө 3°-6°-ийн налуу гадаргатай байна.

Төслийн талбай район далайн түвшнээс дээш 1,153.0-1,379.0 метрийн үнэмлэхүй өндөрт байрлаж, газрын гадаргын налуу буюу хэвгий 0.8-2.4 (градуст) байна.

2.3. Усан сүлжээ: Үйлдвэр байрлах бүс нутаг нь Төв Азийн гадагш урсгалгүй ай сав, Хар нуур Ховд голын сав газарт багтана. Сумын зүүн талд Хар-Ус нуур, баруун хил дагуу Буянт гол, нутгийн хойд хэсэгт Сондуулын гол, Могойн ба Цагаан бургасны гол зэрэг нууруудаас гадна 20 гаруй булаг, шанд цөөрөмтэй учир сумын нутаг, бэлчээрийн ихэнх нь байгалийн задгай усаар хангагддаг юм.

Хар-Ус нуур нь баруун Монголын Их нууруудын хотгор дахь цэнгэг уст нуур. Тус нуур нь Монголд мянгаас дээш хавтгай километр талбайтай дөрвөн нуурын нэг юм. Эргэн тойрондоо Монгол Алтайн нуруугаар хүрээлэгдэнэ. Хар-Ус нуур нь ионы бүрэлдэхүүнээр гидрокарбонатын ус бүхий нуурын ангилалд багтдаг.

Тус нуурын ус цуглуулах талбайн дал орчим хувьд нь Хар нуур-Ховд голын сав газарт хамаарна. Монгол Алтай нуруунаас эх авч урсах Ховд, Буянт гол жилд 2.2 км³ орчим ус нийлүүлэх бөгөөд илүүдэл усаа ууршуулахын хамт 40.0 км урт 50.0-75.0 км өргөн Чоно-Харайх голоор Хар-Ус нуурт өгдөг.

Буянт гол нь Ховд аймгийн Дуут, Жаргалант, Ховд, Буянт, Мянгад сумдын нутгийг дайран өндөр уулын, уулт хээрийн, цөлөрхөг хээрийн зэрэг байгалийн хэд хэдэн бүсийг дамжин урссаар Их Нууруудын хотгорын ай савд ирдэг гол. Хөх Сэрхийн нурууны салбар уулс болох Тахилт уулын далайн түвшнээс дээш 3,400.0 м орчим өндрөөс эх

авч, нийт 8,366.9 км² талбайгаас усаа цуглуулдаг бөгөөд голын нийт урт 171.8 км болно. Ганц модны гол, Чигэртэй, Рашаант зэрэг том жижиг 20 шахам гаруй гол горхи цутгаж Буянт голын усыг сэлбэнэ. Буянт голын эхний урсгал хонхор нь Дэлүүний хоолой хэмээх өргөвтөр хотгор юм. Дээд хэсэгтээ Дэлүүн голд ирж нийлсний дараа Буянт гол нэртэй болдог. Голдирол нь их тахиралддаг, адагтаа олон салбарладаг бөгөөд зарим нь Ховд гол руу, зарим нь Хар ус нуур луу чиглэдэг.

2.4. Үйлдвэрийн талбай орчмын уур амьсгалын горим: Ховд аймаг нь Монгол-Алтайн уулт их муж, говийн зүүн, Алтайн өвөр говийн их мужид багтах 76,060.38 км.кв нутаг дэвсгэртэй. Энд Мөнххайрхан, Хөх сэрх, Цамбагарав, Сутай, Алтан Хөхий, Мянган Угалзат зэрэг том уулууд бий бөгөөд аймгийн нутгийн 20 орчим хувийг говь тал эзэлнэ.

Ховд аймгийн нутгаар Ховд гол, Буянт гол, Булган гол, Чоно харайх гол, Цэнхэр гол зэрэг том голууд урсах бөгөөд Хар-Ус нуур, Хар нуур, Дөргөн нуур, Цэцэг нуур зэрэг том, жижиг нуурууд болон Нэвтийн рашаан, Булганы рашаан, Индэртийн рашаан зэрэг рашаан ус олон бий.

Ховд аймаг уур амьсгалын мужлалын хувьд чийглэг, нэн сэрүүн нэн хүйтэн, чийглэгдүү, сэрүүн нэн сэрүүн, хуурайдуу, сэрүүвтэр нэн хүйтэн, нэн хуурай, дулаан нэн хүйтэн, хүйтэн бүсүүдэд оршдог. Ховд аймгийн нутаг дэвсгэрийн хотгор гүдгэрийн ялгаа ихтэй байдаг учраас өвөл зуны температурын агууриг их ажиглагддаг.


2.5. Хөрсөн бүрхэвчийн төлөв байдал: Үйлдвэрийн талбай орчмын хөрс нь хуурай хээр, цөлийн хээрийн шилжилтийн бүсэд тархсан сийрэг ургамалжилттай, механик бүрэлдэхүүний хувьд элсэрхэг болон хайргархаг шинж давамгай хөрстэй байна.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд тухайн бүс нутгийн хөрс нь ялзмаг багатай, салхи болон усны элэгдэлд өртөмтгий шинжтэй байгаа нь өмнөх судалгааны үр дүнтэй нийцэж байна. Судалгааны талбайн зарим хэсэгт ургамлын бүрхэвч сийрэгжсэн, хөрсний өнгөн үе ил гарсан, механик эвдрэл үүссэн шинж ажиглагдсан нь хөрсний доройтлын эхний шатны төлөв байдалтай байгааг харуулж байна.

Үйлдвэрийн талбайн ойр хөрсний гадаргад ургамлын үндэс ил гарах, хөрсний бүтэц суларсан байдал ажиглагдсан нь салхины элэгдэл болон бэлчээр ашиглалтын нөлөөтэй холбоотой байж болзошгүй байна. Гэсэн хэдий ч үйлдвэрийн талбай нь одоогийн байдлаар хүн, малын шууд нөлөөлөл харьцангуй бага бүсэд хамаарч байгаа тул хөрсний доройтол хязгаарлагдмал түвшинд байна гэж үзэж байна.

Хөрс нь органик бодисын агууламж багатай, нөхөн сэргэх чадамж удаан, эвдрэлд мэдрэмтгий. Иймд үйлдвэрийн үйл ажиллагааны явцад хөрсний өнгөн үеийг хуулалт, тээвэрлэлтийн үед тусгайлан хамгаалах, салхиар хийсэхээс сэргийлэх, эвдэрсэн талбайд нөхөн сэргээлт хийх шаардлагатай.

Ерөнхийд нь авч үзвэл үйлдвэрийн талбай орчмын хөрс нь байгалийн хуурай бүсийн хэв шинж давамгай, элэгдэл эвдрэлд өртөмтгий боловч одоогийн байдлаар хүчтэй бохирдол, доройтол ажиглагдаагүй байна. Цаашид үйл ажиллагааны нөлөөллөөс шалтгаалах хөрсний эвдрэл, бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай.



Зураг 3. Үйлдвэрлэл явагдах талбайн хөрсөн бүрхэвч

Гадаргын болон газрын доорхи ус: Гидрогеологийн мужлалаар тус район нь Түр зуурын элбэг тэжээлтэй ай савын хэсэг болох Монгол Алтайн депрессид хамаарагдана. Төсөл хэрэгжих бүс нь Гол, эх газрын нуурын гаралтай хурдас дахь дундаж ундаргатай уст давхаргаас бүрдэх ба Дөрөвдөгчийн элс, хайрганцар, элсэнцэр, сайр, сайрганцар мөн Дээд цэрдийн элсжин, элс, хөрзөн, хайргажин зэрэг бүрдэлтэй байна. Ховд хот орчмын судалгааны район нь ус зүйн сүлжээний хувьд төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтана.

Гидрогеологийн мужлалаар тус район нь түр зуурын элбэг тэжээлтэй ай савын хэсэг болох Монгол Алтайн депрессид хамаарагдана. Төсөл хэрэгжих бүс нь Гол, эх газрын нуурын гаралтай хурдас дахь дундаж ундаргатай уст давхаргаас бүрдэх ба Дөрөвдөгчийн элс, хайрганцар, элсэнцэр, сайр, сайрганцар мөн Дээд цэрдийн элсжин, элс, хөрзөн, хайргажин зэрэг бүрдэлтэй байна. Ховд хот орчмын судалгааны район нь ус зүйн сүлжээний хувьд төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтана.

Судалгааны районы төв хэсгээр дайран өнгөрөх Буянт гол нь Монгол Алтайн хойд хажуугаас эх аван урсдаг. Буянт голын судалгааны районд хамрагдах хэсэг нь 28км үргэлжлэх бол энэ орчимд урсгалын хурд нь 2.5 м/сек, гүн нь 0.4-1 м байна. Буянт гол тус районы өмнөд хэсэгт орших Бугат үзүүрээс эхлэн 2 салаалан урсах ба Их гүүрнээс дахин нэг салаа нэмэгдээд Улаан богочоос эхлэн буцаж нийлнэ. Ховд хотын төвийн хойгуур салаалан урсах Буянт голын 2 салааг нутгийнхан Их ба Бага гол гэж нэрлэн иржээ.


2.6. Ургамлын нөмрөгийн төлөв байдал: Ургамал газар зүйн мужлалын хувьд тус район нь Евроазийн хээрийн их мужийн, Төв азийн муж, Алтайн хээрийн дэд хэв шинжийн ургамалтай. Ургамалжилтын ангиллаар бэсрэг уулс болон нам өндөр уулсын бүсэд хамаарах бөгөөд ургамал-газарзүйн мужлалаар Евро-Азийн мужийн Монгол Алтайн уулын хээр, цөлийн хээрийн шилжилтийн бүсэд оршино.

Ургамлын ташингын бүтцэд сөөг, сөөгөнцөр ургамал дээд ташингад, олон наст өвслөг ургамал дунд ташингад, өнгөрсөн жилийн борог өвс болон хагд доод ташингад тус тус зонхилон оролцож байна. Хашаалсан талбайд ургамлын ташингын ялгарал харьцангуй тод ажиглагдана.

Судалгааны талбайн ургамлын нөмрөгийн дундаж бүрхэц 61%, ургамлын зүйлийн бүрэлдэхүүн харьцангуй сайн, ургамлын дундаж өндөр 28–45 см байна. Судалгааны бүс нь малчдын өвөлжөө, хаваржааны бүсээс зайдуу байрладаг тул одоогийн байдлаар малын шууд нөлөөлөл харьцангуй бага байна. Гэвч зарим хэсэгт хөрсний элэгдэл, ургамлын бүрхэвчийн сийрэгжилт ажиглагдах бөгөөд бэлчээрийн төлөв байдал дунд зэрэг доройтсон үнэлгээтэй байна.

Судалгааны талбайд *Stipa krylovii*, *Anabasis brevifolia* C.A.Mey., *Agropyron cristatum* L., *Caragana bungei*, *Atraphaxis pungens* Jaub. зэрэг ургамлын зүйлүүд зонхилон ургаж байна.

Талбайн зарим хэсэгт ургамлын бүрхэвч сийрэгжиж, хөрсний ил задрал үүссэн шинж ажиглагдах бөгөөд ганц нэг ургамлын үндэс хөрсний гадаргад ил гарсан байдал ажиглагдана.



Зураг 4. Төслийн талбайн ургамалжилтын зураг

2.7. Амьтны аймаг: Амьтны аймгийн газарзүйн тойргоор их нууруудын хотгорын тойрогт хамаарна. Үйлдвэрийн орчимд амьтны ул мөр харьцангуй цөөн ажиглагдсан боловч уг талбай нь биологийн олон янз байдлын хувьд экологийн ач холбогдол өндөртэй бөгөөд Хар ус нуур болон Буянт гол зэрэг нуур, гол мөрний ойролцоо байрладаг. Иймд эдгээр усан орчны нөлөөгөөр усны шувууд болон хөхтөн амьтдын олон зүйл тархах, нутагших таатай экологийн нөхцөл болно.

Буянт сумын хэмжээнд 6 багт хамаарах 36 зүйл хөхтөн амьтан зүйл хөхтөн амьтан, мөн олон улсын болон бүс нутгийн хамгаалалтын ач холбогдол бүхий 90 гаруй зүйл шувуу тохиолдох боломжтой нь тогтоогдсон. Үүнээс Хошуу галуу (*Anser cygnoides*), Хээрийн бүргэд (*Aquila nipalensis*), Идлэг шонхор (*Falco cherrug*) зэрэг олон улсын хэмжээнд ховордлын зэрэглэлтэй зүйлүүд бүртгэгдсэн нь тухайн бүс нутгийн хамгааллын үнэ цэнийг илтгэнэ. Эдгээр хөхтөн амьтдын зүйлийн бүрэлдэхүүнийг судалгааны талбайн байгаль-экологийн нөхцөл, ялангуяа ус, намгархаг газар, голын хөндий, хээрийн бүсийн амьдрах орчны онцлогтой уялдуулан тодорхойлсон.

Үйлдвэрийн талбай нь Монгол орны шувуудад чухал газар. Ус намгархаг газар болон усны шувууд олноор амьдардаг орчныг хамгаалах тухай Рамсарын конвенц, түүнчлэн Хар Ус нуурын байгалийн цогцолборт газар зэрэг хамгаалалтын ач холбогдолтой газар нутгийн хилийн гадна оршиж байна. Бүс нутгийн хэмжээнд авч үзвэл Хар Ус нуур ба түүний эргэн тойрны газар нутаг нь амьдрах орчны олон янз байдлыг агуулсан бөгөөд үүний нөлөөгөөр шувуудын зүйлийн бүрдэл ч өндөр ажээ. Хар Ус нуур орчимд одоогийн байдлаар 17 багийн 35 овогт хамаарах 280 орчим зүйлийн шувууд бүртгэгдсэн (Ц. Пүрэвсүрэн, 2017).

Цементийн үйлдвэрийн үйл ажиллагааны явцад тоосжилт, дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хий ялгаралт болон хүний үйл ажиллагааны эрчимжилт нэмэгдэх нь амьтдын амьдрах орчинд тодорхой хэмжээгээр нөлөөлөх эрсдэлтэй.

2.8. Түүх соёлын биет өв, дурсгалууд: Буянт сум нь түүх, соёлын өвөөр баялаг нутаг бөгөөд эртний нүүдэлчдийн соёл, шашин, ахуйтай холбоотой олон дурсгал хадгалагдан үлдсэн байдаг. Тус сум болон ойр орчмын бүсэд дараах түүх, соёлын биет өвүүдийг дурддаг

- Эртний булш, хиргисүүрүүд: Буянт сумын нутагт хүрэл болон төмөр зэвсгийн үеийн булш, дөрвөлжин булш, хиргисүүр элбэг тархсан байдаг. Эдгээр нь Баруун Монголын нүүдэлчдийн соёл иргэншлийн чухал дурсгалд тооцогдоно;
- Хадны зураг, бичээснүүд: Буянт голын сав дагуу болон уул хадтай газруудад эртний хүмүүсийн ан агнуур, мал аж ахуй, зан үйлийг дүрсэлсэн хадны зураг бий. Зарим газарт түрэг, Уйгур үеийн руни бичгийн хэлбэртэй бичээснүүд илэрсэн талаар судалгаанд дурдсан байдаг;
- Сүм хийдийн туурь: 1930-аад оны хэлмэгдүүлэлтийн өмнө байсан жижиг хийд, дугануудын туурь үлдсэн. Эдгээр нь нутгийн шашин, соёлын хөгжлийн түүхийг илтгэнэ;
- “Цайны зам”-ын түүхэн үл мөр: Ховд нутгаар дайран өнгөрдөг байсан эртний худалдааны “Цайны зам” нь Буянт сумтай холбоотой түүхэн өвд тооцогддог;
- Нүүдэлчдийн уламжлалт сууц, ахуйн дурсгал: Казах, Урианхай, Захчин зэрэг ястны уламжлалт гэр сууц, эдлэл хэрэглэл, гар урлал нь биет соёлын өвийн нэг хэсэг юм.

2.9. Хүн ам, эдийн засаг, зам харилцаа: Ховд аймгийн Буянт сум нь Алтайн уулархаг муж, Их нууруудын сав газарт 367950 га нутаг эзлэн оршдог. Газар хөдлөлийн эрчим 8 балл. Сумын нутаг дэвсгэрээр улсын чанартай засмал зам дайрч өнгөрдөг ба баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон зэрэг дэд бүтцийн давуу талуудтай. Улаанбаатар хотоос 1512 км, Аймгийн төвөөс 25км зайд байрладаг. Зүүн талаараа Ховд аймгийн Мянгад сум, урд талаараа Чандмань, Манхан сум, баруун талаараа Дуут сум, хойд талаараа Ховд сумтай хиллэдэг. Буянт сум нь засаг захиргаа нутаг дэвсгэрийн хувьд Норжинхайрхан, Нарийн гол, Цагаан бургас, Наранхайрхан, Цагаан эрэг гэх 5 багтай.

1. **Хүн ам, өрх:** Ховд аймгийн Буянт сумын суурин хүн амын тоо 2024 оны жилийн эцэст 3734 хүрсэн нь өмнөх оноос 66-аар нэмэгдсэн

үзүүлэлттэй байна. Хүн амын нас хүйсийн бүтцээр авч үзвэл 1990 эрэгтэй 1744 эмэгтэй.

- 2. Урианхай, халх, өөлд, захчин, торгууд, дөрвөд, баяд, казах, Тува, Чантуу зэрэг 10 гаруй угсаатны бүлэгтэй.
- 3. Буянт сумын хэмжээнд 2023 оны байдлаар нийт 950 өрх амьдарч байсан бол 2024 онд 1022 өрх болж нэмэгдсэн үзүүлэлттэй байна.
- 4. *Өрхийн үзүүлэлт:* Сумын хэмжээнд 2024 оны байдлаар 1022 өрх амьдарч байгаа ба 2022 онтой харьцуулахад 76 өрхөөр өсөн үзүүлэлттэй байна.
- 5. *Мал сүрэг:* Малын бүтэц 2024 оны жилийн эцсээр адуу 15.9 мян.толгой, үхэр 27.3 мян.толгой, хонь 76.7 мян.толгой, ямаа 128.2 мян.толгой, тэмээ 0.5 мян.толгой тус тус тоологдсон ба нийт сумын хэмжээнд 248.6мян.толгой мал тоологдсон байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

3.1. Төслийн гол болон болзошгүй нөлөөлөл: “Вестерн Холд” ХХК-ийн “Ховд цемент” баруун бүсийн цементийн үйлдвэрийн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг өмнөх хэсэгт авч үзсэнийг нэгтгэвэл 36 үзүүлэлтээр нөлөөллийн эрчмийг тодорхойлсноос эдэлбэр газарт 9.0 хувь, агаарын чанарт үзүүлэх нөлөө 13.0 хувь, гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх нөлөө 22.0 хувь, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл 22.0 хувь, ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөөлөл 13.0 хувь, амьтны аймагт 4.0 хувь, үлдсэн 17 хувь нь нийгэмд үзүүлэх эерэг нөлөөлөл эзэлж байна. Төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн 36.0 % нь тодорхой нөлөөгүй байхад, 45.0 % нь бага, 19.0 % нь дунд эрчимтэй байгаа ба агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчим байгаль орчны бусад бүрдэл хэсгүүдээс их байна.

БОНЕТ-ний дүгнэлтэд тусгасан гол шалгуурууд болон урьдчилан тодорхойлсон сөрөг нөлөөллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3. БОНЕТ-ний гол шалгуурууд болон сөрөг нөлөө үүсэх нөхцөлүүд

Нөлөөллийг тодорхойлох шалгуур үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй нөхцөлүүд
Хүний нөлөө болон байгаль, цаг уурын өөрчлөлтөд эмзэг, эсэх.	- Ган, зуд зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдох магадлал харьцангуй бага
Орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн газар байгаа эсэх.	- Уг үйлдвэр нь Ховд аймгийн Буянт сумын нутагт байрлана. - Ойрын хугацаанд төлөвлөсөн төлөвлөлт байхгүй.
Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсэх эсэх.	- Хуримтлагдах нөлөөлөл үүсэхгүй.
Төслийн БО-ны нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд	

Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл: - Бохирдуулагч болон аюултай, хортой бодис ялгаруулах, эсэх; - Дуу чимээ, доргио чичиргээ, дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсгэх, эсэх.	- Цементийн үйлдвэрээс үүсэх бохирдуулагч бодисын тооцоо жилд 54.4 тонн бохирдуулагч бодис үүснэ.
Усан орчинд үзүүлэх нөлөөлөл: - Усны нөөцөд хомсдол үүсэх, эсэх; - Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх.	- Төслийн ус хэрэглээг өөрийн эзэмшлийн гүний 2 худгаас хангана. Унд, ахуйн хэрэглээнд жилд нийт 6,205.5 м³ ус ашиглах ба үүний 70 хувь буюу 4,343.85 м³ ус шингэн хаягдал болно.
Хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөө: - Хөрс эвдрэх эсэх; - Хөрс бохирдох эсэх; - Хөрс доройтох цөлжих эсэх.	- Төслийн хүрээнд нийт эзэмшил газрын 40.0 % нь хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн байна. Үүнээс зам (18,226.0 м²), овоолго (4,855.0 м²), барилга, байгууламж (24,834.6 м²), ногоон байгууламж (1,830.8 м²), хог хаягдлын талбай (7,395.1 м²), цементэлсэн талбай (2,649.1 м²), тоног төхөөрөмж (2,194.7 м²), нүүрс буулгасан талбай (11,990.76 м²) байна. Нийт 73,976.06 м² талбай үйл ажиллагаанд өртсөн байна; - Цементийн түүхий эд, цемент тээвэрлэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр хөрсний элэгдэл эвдрэл ихэснэ.
Ургамлын нөмрөгт үзүүлэх нөлөө: - Ургамлын нөмрөг, ой мод өртөх эсэх; - Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйл өртөх эсэх.	- Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр нийт эдэлбэрийн газрын 40.0 % буюу 73,976.0 м² талбай нь үйл ажиллагаанд өртсөн байна. Иймд биет хэмжээгээр төслийн талбайд тархсан ургамлын нөмрөг устана; - Тээврийн хөдөлгөөний хөлөөр үүсэх тоосжилт орчны ургамалжилтад дам нөлөөлнө.
Ан, амьтанд үзүүлэх нөлөө: - Зэрлэг амьтдын амьдрах орчныг доройтуулах эсэх; - Ховор болон нэн ховор амьтан өртөх эсэх.	- Төслийн талбай нь сумын төвөөс урд зүгт 16.0 км зайд байрлана. - Төслийн талбайн ойр орчимд ховор болон нэн ховор амьтдын тогтмол тархац, амьдрах орчин бүртгэгдээгүй тул сөрөг нөлөөлөл үүсэх эрсдэл бага байна; - Тухайн орчимд ан амьтдын идэвхжил, нягтаршил харьцангуй бага байна.
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд авч үзсэн асуудлууд:	

Орон нутгийн оршин суугчдад үзүүлэх нөлөө: - Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх эсэх; - Оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөтэй эсэх; - Нөлөөлөлд өртөж болзошгүй төв суурин газар байгаа эсэх; - Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх эсэх.	- Ховд аймгийн буянт сумын Засаг даргын 2025 оны 04 сарын 21-ний өдрийн А/51 тоот захирамжтай 3 газрын нийт 20.0 га талбайд үйл ажиллагаа явуулж байна; - Төслийн талбайн ойр хавьд нөлөөлөлд өртөгч суурин газар байхгүй. Төслийн ажилчид нөлөөлөлд өртөгчид болно; - Төслийн үйл ажиллагаанаас нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэхгүй.
Түүх, соёлын өвд үзүүлэх нөлөө: - Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйл бий эсэх.	- Одоогоор төслийн талбайд түүх соёлын үнэт зүйл илрээгүй болно.
Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл: - Нутгийн иргэд, оршин суугчдад сөргөөр нөлөөлөх эсэх; - Төслийн бүхий л үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх эсэх.	- Төслийн үйл ажиллагаа улирлын чанартай явагддаг; - Төслийн технологи ажиллагаанд 101 нэр төрлийн нэмэлт химийн бодис ашиглана; - Төслийн хэрэгжилтийн хүрээнд дагаж мөрдөх хөдөлмөр хамгааллын харилцааг төсөлд тусгайлан заасан байна.

Сөрөг нөлөөллийг ийнхүү урьдчилан тогтоож, онцгойлон анхаарах зүйлсийг тодорхойлсноор төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүний хамрах хүрээ, учруулах хохирлын хэмжээг урьдчилан тооцож ажиллахад дөхөм болж байна.

3.2 Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөлөл:

Хүснэгт 4. Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл

Байгаль орчны хэсгүүд	Төслөөс үзүүлэх болзошгүй сөрөг нөлөө
Агаар	- Цементийн үйлдвэрээс үүсэх бохирдуулагч бодисын тооцоо жилд 54.4 тонн бохирдуулагч бодис үүснэ.
Газар	- Төслийн хүрээнд нийт эзэмшил газрын 40.0 % нь хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн байна; - Төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр үүсмэл хэлбэршлээр солигдоно.
Ус	- Төслийн ус хэрэглээг өөрийн эзэмшлийн гүний 2 худгаас хангана. Унд, ахуйн хэрэглээнд жилд нийт 6,205.5 м ³ ус ашиглах ба үүний 70 хувь буюу 4,343.85 м ³ ус шингэн хаягдал болно.

Хөрс	- Төслийн хүрээнд нийт эзэмшил газрын 40.0 % нь хүний үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн байна. Үүнээс зам (18,226.0 м²), овоолго (4,855.0 м²), барилга, байгууламж (24,834.6 м²), ногоон байгууламж (1,830.8 м²), хог хаягдлын талбай (7,395.1 м²), цементэлсэн талбай (2,649.1 м²), тоног төхөөрөмж (2,194.7 м²), нүүрс буулгасан талбай (11,990.76 м²) байна. Нийт 73,976.06 м² талбай үйл ажиллагаанд өртсөн байна; - Иймд биет хэмжээгээр хөрсөн бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдоно; - Төслийн талбайд техникийн нөлөөнөөс болж хөрс доройтож цөлжилт үүсэж болзошгүй; - Ахуйн хатуу, шингэн хог хаягдал, тээврийн хэрэгсэл, машин механизмын засвараас гарах хаягдал тос, масло асгарснаас хөрс бохирдож болзошгүй.
Ургамлын нөмрөг	- Төслийн үйл ажиллагааны нөлөөгөөр нийт эдэлбэрийн газрын 40.0 % буюу 73,976.0 м² талбай нь үйл ажиллагаанд өртсөн байна; - Иймд биет хэмжээгээр төслийн талбайд тархсан ургамлын нөмрөг устана.
Амьтны аймаг	- Төслийн талбайн ойр орчимд ховор болон нэн ховор амьтдын тогтмол тархац, амьдрах орчин бүртгэгдээгүй тул сөрөг нөлөө илрэхгүй.

3.3 Нийгэм-эдийн засагт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл: Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралт “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-аар эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, өрсөлдөх чадвартай бүсийг харьцангуй тэнцвэртэйгээр хөгжүүлнэ хэмээн баталсан. Баруун бүсэд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг хамрах бөгөөд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд “Ховд аймагт бүсийн бүтээн байгуулалтын хэрэгцээг хангах барилгын материалын хангамжийн төв байгуулна” гэж тусгасан байдаг.

“Вестерн холд” ХХК-ийн барих цементийн үйлдвэр ашиглалтад орсноор баруун бүсийн аймгуудын цементийн хэрэгцээг бүрэн хангаад зогсохгүй Монгол Улсын цементийн одоогийн нийт импортыг бууруулах боломжийг нээж өгч байна.

Орон нутгийн байдал: Цементийн үйлдвэр нь Баруун бүсийн хөгжлийн тулгуур төв Ховд аймгийн Буянт сумын нутагт Шохойт ордын дэргэд аймгийн төвөөс 15 км байрлана. Хил залгаа аймгуудтай холбогдох тээврийн зай харьцангуй ойр, авто замын хэвтээ болон босоо тэнхлэг дээр байрлана.

Оролцогч талууд ба олон нийт: Төслийн талбайн баруун болон хойд зүгт 16.0 км зайд Буянт сум, баруун урд зүгт 15 км зайд Ховд аймгийн төв байрлаж байна. Ойролцоогоор зүүн зүгт 0.3 км зайд засмал зам байрлаж байна. Ховд аймгийн Буянт сумын Засаг даргын 2025 оны 11 сарын 17-ны өдрийн 1/276 дугаартай албан бичгээр БОУАӨЯ-нд өгсөн саналдаа “Вестерн Холд” ХХК-тай хамтран ажиллахад татгалзах зүйлгүй болохыг тэмдэглэсэн байна.

Хүснэгт 5. Судалгаанд оролцогсдын саналыг эрэмбэлсэн байдал

д/д	Судалгаанд оролцогсод	Төсөлд оруулах санал
1	Оршин суугчид	Төслийн үйл ажиллагаанаас ахуй амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөө байхгүй. Нутгийн иргэдийг ажлын байраар хангах, хог хаягдлыг нэгдсэн цэгт хаях.
2	Засаг дарга	Орон нутгийн зүгээс татгалзах зүйл үгүй.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх.

Ховд аймгийн Буянт сумын нутагт орших “Вестерн Холд” ХХК-ийн “Ховд цемент” баруун бүсийн цементийн үйлдвэрийн төслийн 5 жилийн БОМТ-г БОУАӨЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ийг баримтлан боловсруулсан болно.

- Монгол улсын “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь заалтын дагуу төсөл хэрэгжүүлэгч жил бүрийн 12 дугаар сард багтаан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагаар батлуулж байх шаардлагатай:
 - Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ханган биелүүлж түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор энэхүү журмын 3-р хавсралтын дагуу гаргаж, харьяалагдах аймаг, Ховд аймгийн байгаль орчны газарт хэвлэмэл хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ;
 - Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэлийн томилсон ажлын хэсэг газар дээр нь хянаж үнэлсэн нэгдсэн дүн 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байвал дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийн хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (Төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал (Төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
1	Агаарын бохирдол үүсэх	Ил задгай хог хаягдал шатаахгүй байх	Төслийн талбайд	Тогтмол	-	-	100,000	Жил бүр	Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль MNS 4585:2025
2	Авто тээврийн хэрэгслээс хорт хий ялгарах, дуу чимээ тархах	Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглаж буй машин техникийг үзлэг, оношилгоонд тогтмол оруулж, засвар үйлчилгээг шаардлагын дагуу хийж гүйцэтгэж байх	Үйлдвэрийн машин	Жилд 1 удаа	-	-	1,000,000	Жил бүр	
3	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Үйлдвэрийн үнс, тоос баригч төхөөрөмжийн фильтрийг шалгаж тогтмол хугацаанд солих.	Үйлдвэрийн зуухнууд ба яндан	Улиралд 1 удаа	-	-	6,000,000	Жил бүр	
Дүн							7,100,000		
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
1		Борооны ус хуримтлуулан дахин ашиглах зөвлөмж	Ус хэмнэх	Ширхэг	1 удаа		100,000	Жил бүр	“Усны тухай хууль” Ус

2	- Усан орчин бохирдох, -Усны нөөц хомсдох	Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах	-Төслийн талбай - Бохир ус зайлуулах цооног, түүнээс үүсэх бохирдлыг хязгаарлах	Удаа	200,000			Жил бүр	бохирдуулсны төлбөрийн тухай хууль “Усны тухай хууль” БОУАӨЯ-ны сайд, БХБ-ын сайдын хамтарсан тушаал-А-230/127 тоот журам БОУАӨЯ-ны сайд, ЭМ-ын сайдын хамтарсан тушаал-А/82/128 тоот журам хамтарсан тушаал-А/82/128 тоот журам
3	-Усны чанар	Цэгийн орчны газрыг тэгшилж, хур борооны ус, чийг шүүрч нэвчихээс сэргийлж гадаргын урсац зайлуулах суваг татах					800,000	2027 он	
4		Ус ашиглагч нь цэгийн эзлэхүүний 70-80 хувь дүүрсэн үед суллаж, цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ.		Удаа	150,000	40	600,000	Жил бүр	
Дүн							1,700,000		
Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
1	Хөрсний бохирдол	Авто машины зогсоол дээр асгарсан тос, тосолгооны материалыг тухай бүрд нь цэвэрлэж авах	Төслийн талбайд	удаа	200,000			Жил бүр	MNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Дүн							200,000		
Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
1	Амьтан	Цахилгаан дамжуулах шугамын шувуунд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж	Төслийн талбайн цахилгааны шугам	ширхэг	100.0	1	240,000	Жил бүр	Амьтны тухай хууль

2	Цөлжилтөөс урьдчилсан сэргийлэх	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж жилд 10,000 ширхэг мод тарина.	Хөрс, ургамал, агаар орчин	ширхэг	15,000.00	3,000 ш	Нийгмийн хариуцлагын хүрээнд гэрээний үнийн дүнгээр хийгдэх ажил 750,000.00	Жил бүр	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн
Дүн							240,000		
Нийт дүн							10,000,000		

5.2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

“Газрын тухай хууль”-ийн 56.6-р зүйл: Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байна.

Хүснэгт 7. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хар шороо /бууц/	Хар шороо, элс, бордоо зэргийг бэлтгэх	Ногоон байгууламжийн арчилгаа	Машин	5	272,000	Жил бүр	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260:2011
2	Бордоо			кг	250	200,000	Жил бүр	
3	Гумины бордоо			л	650	500,000	Жил бүр	
4	Цалин	2 хүн ажиллах /жилд 2 Удаа/		Өдөр	2	600,000	Жил бүр	
5	Дуслын усалгааны систем	Дуслын усалгааны систем		-	-	2,000,000	Жил бүр	
6	Тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж		-	-	1,000,000	Жил бүр	
Нийт дүн						4,572,000		

5.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор төсөл хэрэгжүүлэгч нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх;

- Төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-ын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэг хүлээн ажиллана.

Хүснэгт 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал /төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирж болзошгүй.	Хэрэв төслийн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирэхэд төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Төсөл хэрэгжүүлэх нийт талбайн хэмжээнд	-	1,000,000	Тухайн үед нь шийдэх	Үйл ажиллагааны турш	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/, Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд
Нийт дүн					1,000,000			

5.4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 9. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал төг	Нийт зардал , төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Нийт ажилчид	Жилд 1 удаа	197 хүн	1,000,000		Жил бүр	Гамшгаас хамгаалах тухай хууль Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль MNS 5002:2000, “ХАБЭА. Шуугианы норм,
2	Олон нийт, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл	Төслийн тухай мэдээллийн самбар, ажил эхлэх, дуусах хугацаа, холбоо барих хаяг, талбайн удирдах ажилтан, ачааны машинуудын явах зам, төслийн зохион байгуулалт зэргийг мэдээлнэ;	Төслийн талбай	Иж бүрэн	1	500,000		2026 он	
4		Ажлын идэвхтэй талбайг тойруулан хангалттай/зохистой гэрэлтүүлж, гэрэл цацруулагч саад тавих;	Төслийн талбай	Иж бүрэн	1	2,000,000		2026 он	

5	Олон нийт, ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл	Ажиллагсдыг ХАБЭА -н хувцас хэрэгсэл буюу бээлий, малгай, хормогч, маск, хошуувч, хамгаалах хэрэгслээр бүрэн хангах, хэрэглүүлж хэвшүүлэх;	Төслийн бүх ажилчид	Иж бүрэн	Жил бүр	3,000.0* /Гэрээний үнийн дүнгээр/	Жил бүр	аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага”
6		Төслийн бүх ажилчдад өдөр бүр ажил эхлэхээс өмнө ХАБЭА -н зааварчилгаа өгч гарын үсэг зуруулах, ХАБЭА-н зааварчилгаанд хамрагдаагүй ажилчдыг тухайн өдөрт ажиллахыг хориглох		-	Өдөр бүр	100,000	Жил бүр	MNS ISO 13688:2000, “ХАБЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага”
7		Төслийн хүрээнд ашиглагдах техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих	Иж бүрэн	Иж бүрэн	Өдөр бүр	100,000	Жил бүр	MNS 5390:2004, “ХАБЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
8		Ажилчдад анхны тусламж үзүүлэх арга зааврыг эзэмшүүлэх, анхан шатны тусламжийн эм, тариа, багажийг хяналтын өрөө эсвэл ажлын байруудын аль тохиромжтой газар байрлуулах	Төслийн бүх ажилчдад	Удаа	Тухай бүр	500,000	Жил бүр	
9		Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах	Төслийн талбай	Удаа	Жилд 1 удаа	500,000	Жил бүр	
10		Ажилчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэг, шинжилгээнд хамруулах	Ажилчдад	Жилд 1 удаа	197 хүн	200,000	Жил бүр	
11		Болзошгүй аюул ослын үед ашиглах бүрэн ажиллагаатай галын хор, багаж хэрэгслүүдийг бүх объектуудад байрлуулах, галын аюулын үед ашиглах ослын гарцын зураглал хийж үйлдвэрийн доторх хананд байршуулах /Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл болох лоом, хүрз, сүх, хөрөө, хувин, хоолой, багор дэгээ, жоотуу, тармуур, хөөс, хорны суурь, тэмдэг тэмдэглээ, сарай, элсний хайрцаг, шланк зэргийг бэлэн байлгах./	Төслийн талбай	Тогтмол		1,000,000* /Гэрээний үнийн дүнгээр/	Жил бүр	Галын аюулгүй байдлын тухай хууль, 1999 он Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 он Хөдөлмөр хамгаалал стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий

12	Галын аюул гамшиг осол аюул	Онцгой байдлын газартай хамтарч гэнэтийн гал түймэр, гамшиг осолтой тэмцэх аргачилсан заавар зөвлөгөөг боловсруулж (ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөө) тусгах, өөрөөр хэлбэл авах ёстой арга хэмжээний дэс дарааллыг тодорхой тусгаж, хариуцах эзэнтэй болгох	Төслийн талбай	Тогтмол		1,700,000	Жил бүр	шаардлагаMNS 4244:94 Хөдөлмөр хамгаалал стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага MNS4244:94 Гал гарах үед анхааруулгын самбар, объектоос гарах схем зураглал, галын хорын нэгж талбайд ноогдох стандарт MNS 5566: 2005
13		Гамшиг, ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөөг ажилчдад таниулж сургах ба сургалтын протокол хөтөлж баримтжуулах	Төслийн талбай	Иж бүрэн	Жилд 1 удаа	500,000	Жил бүр	
Нийт дүн						7,100,000		

*гэрээний үнийн дүнгээр шийдвэрлэнэ.

5.5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын цэгийг тохижуулах	Хог хаягдлын цэг	Иж бүрэн	1 удаа	400,000	400,000	2026 он	БОУАӨЯ-ны сайдын А/433 тогтоол Хог хаягдлын тухай хууль
2	Эзэмшил газрын ил задгай хаягдсан хогийг ангилан ялгаж цэвэрлэж байх	Үйлдвэрийн ойр орчмын 100 м-т	Тогтмол	100,000		Жил бүр		
3	Төслийн талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах	Төслийн талбайд	Иж бүрэн	1 удаа	-	1,000,000	Жил бүр	
4	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Дахин ашиглагдах хог хаягдал	Тогтмол	200,000		Жил бүр		
5	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Хог хаягдлын цэгт	Тогтмол	Улиралд 1 удаа	50,000	200,000	Жил бүр	
6	Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх сургалт хийх	Үйлдвэрийн ажилчдад	Удаа	0,0		Жил бүр	Засгийн газрын 116 тогтоол	

7	Сумын нэгдсэн хогийн цэгийг булж янзлах	Төслөөс үүсэх хог хаягдал	Удаа	Дотоод зардлаар	Жил бүр	
Нийт дүн				1,900,000		

5.6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр


БОМТ-ний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан мониторингийн цэгээс хөрс, ус, агаарын дээжийг тогтмол хугацаанд авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэж. Байгаль орчны хяналт шинжилгээний тайлангийн үр дүнг жил бүрийн БОМТ-ний биелэлтийн тайланд тусгаж төсөл хэрэгжих багийн удирдлага болон нөлөөллийн бүсийн иргэдэд нээлттэй мэдээлж байх шаардлагатай.

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нэгж, төг	Хууль, бодлого, стандарт
Агаарын чанар						
CO2, NO2, SO2 Нийт тоосонцор, Дуу шуугиан хэмжээ	- Үйлдвэрийн байр дотор -3 цэг - Төслийн талбайн хашаан дотор-2 цэг	Улиралд 1 удаа	5 цэгт	700.0 төг*1 жил	700,000	MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн шаардлага
NOx, SO2, CO2, TSP /нийт тоос/	- Үйлдвэрийн зуух	Жилд 1 удаа	1 цэгт	2,000.0 төг*1 жил	2,000,000	MNS 5919:2008 Уурын зуухны стандарт
Цацрагийн хэмжилт K-40 Ra-226 Th-232 Радийн эквивалент	- Төслийн талбай дотор 2 цэг - Үнснээс 1 цэг	Жилд 1 удаа	3 цэгт	105.0 төг*1 жил	105,000	ЦАН-2015
Хөрс						
Нянгийн шинжилгээ/ Нянгийн ерөнхий тоо, гэдэсний бүлгийн нянгийн тоо, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян, E.Coli халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо/	- Ариун цэврийн байгууламж-1 цэг - Хогийн цэг – 1 цэг	Жилд 1 удаа	2 цэгт	55.0 төг*1жил	55,000	MNS 3297:2019, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх” MNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
Хөрсний агрохими, хөрсний зарим хүнд металлууд	- Төслийн талбайн ил гарсан хөрснөөс-3 цэг	Улиралд 1 удаа	3 цэгт	699.6 төг*1 жил	699,000	
Усны чанар						
Усны ерөнхий хими, Бактериологи	- Унд, ахуйн ус	Улиралд 1 удаа	1 цэгт	300.0 төг*1жил	300,000	MNS 0900:2018 “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ”

Нийт ОХШХ-ийн зардал

3,859,600



Зураг 5 Орчны хяналт шинжилгээний цэгийн байршлын зураг

5.7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	400,000	Үйлдвэрийн захирал	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
2	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10 ¹ болон БО-ны ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх	4,000,000 /Гэрээний үнийн дүнгээр/*	Үйлдвэрийн захирал	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчны аудит хийх эрх олгох журам, БОУАӨЯ-ны сайдын 2019 оны А/618 тоот тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
3	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх	1,000,000 /Гэрээний үнийн дүнгээр/*	Үйлдвэрийн захирал	Газрын тухай хуулийн 58.5
Нийт		5,400000.0		

*Гэрээний үнийн дүнгээр шийдвэрлэнэ.

5.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч нь үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ.

Хүснэгт 13. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх арга хэлбэр	Мэдээний агуулга	Хугацаа-ны тов	Тайлагнах зардал мян.төг	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан
Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	БОМТ-н жилийн төлөвлөгөө	БОННУ-р тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулах, зөвлөмж, батлагдсан БОМТ-нд үндэслэн тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах	Жил бүрийн 12-р сард	300,000	Төлөвлөгөө батлуулах	"Вестерн Холд" ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн
Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам, Ховд аймгийн БОГ	БОМТ-н жилийн тайлан	Төлөвлөгөөний хэрэгжилт, ОХШХ-н хэрэгжилт	Жил бүр 11-р сарын 1-ний дотор	400,000	Тайлан хянуулах	"Вестерн Холд" ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн
Буянт сумын Норжинхайрхан иргэд	ИНХ-д танилцуулах	Тухайн жилд хийгдсэн ажил	Тухайн оны 4-р улирал	500,000	Тайлан танилцуулах	Вестерн Холд" ХХК-ийн байгаль орчны мэргэжилтэн
Нийт дүн			-	1,200,000		

5.9. “Ховд Эко Цемент” үйлдвэрийн 2026 оны БОМТ-ний нийт зардал

Хүснэгт 14. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах

№	Арга хэмжээ	2026 он
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	10,000,000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	4,572,000
3	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	1,000,000
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө*	7,100,000
5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,900,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,859,600
7	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө*	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа (5,000,000)
8	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	1,200,000
9	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж жилд 10,000 ширхэг мод тарина*	Нийгмийн хариуцлагын хүрээнд гэрээний үнийн дүнгээр хийгдэх ажил (150,000)
Нийт		22,531,600

*гэрээний үнийн дүнгээр шийдэгдэх тул БОМТ-ний нийт төсөвт тусгах боломжгүй зардал.